

Монгол Улс дахь зөөлөн хүчний бодлогын нөлөөг гадаадын шууд хөрөнгө оруулалтад хандах иргэдийн хандлагаар судлах нь

Ариунсангийн Гантуяа*

Шанхайн Жиатун их сургуулийн Олон улсын харилцаа

Нийтийн удирдлагын сургууль. Докторант.

Цахим хаяг: gariunsan@sjtu.edu.cn, <https://orcid.org/0000-0003-4585-5056>

Төмөрчулууны Заяа

ХУИС-ийн Олон улсын харилцаа, нийгэм судлалын сургуулийн багш

Цахим хаяг: zaya.t@humanities.mn, <https://orcid.org/0000-0002-4313-6915>

Хураангуй: Энэхүү судалгаанд Монгол Улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтанд хандах олон нийтийн хандлагын талаар авч үзлээ. Судалгаанд “олон нийтийн хандлага нь хүчирхэг улсын зөөлөн хүчний бодлогын нөлөөнөөс хамааралтай байдаг” хэмээх онолын үндэслэлд тулгуурласан болно. Түүвэр судалгаанд хүн ам зүйн үзүүлэлтүүдийг жигд төлөөлж чадах 383 иргэнийг хамруулсан. Цуглуулсан мэдээлэлд корреляцийн шинжилгээ хийж, хүчин зүйлсийн хамаарлыг тодруулсан. Түүнчлэн мэдээлэл боловсруулалтын явцад гарсан үр дүнг илүү тодотгох үүднээс БНХАУ болон БНСУ-ын зөөлөн хүчний нөлөөллийг Монголын кейс дээр харьцуулан авч үзэв. Өгүүллийн практик ач холбогдол нь зөөлөн хүчний нөлөөллийг явцуу хүрээнд, эмпирик байдлаар судалсан явдал юм.

Түлхүүр үгс: гадаадын хөрөнгө оруулалт; зөөлөн хүч; олон нийтийн хандлага

Зөөлөн хүчний бодлого ба олон нийтийн хандлага

Улс төр, олон улсын харилцааны шинжлэх ухаанд “хатуу хүч” (hard power), “зөөлөн хүч” (soft power), “ухаалаг хүч” (smart power)-ийн талаарх ойлголтуудыг өргөн дэлгэр хэрэглэж байна. Зөөлөн хүчний онолын үндэслэлийг Харвардын Их сургуулийн профессор Жозеф Най (Joseph Samuel Nye Jr.) 1990 онд анх дэвшүүлж 14 жилийн дараа 2004 онд нэрд гарсан *The Soft Power: The Means to Success in World Politics* (Зөөлөн хүч бол дэлхийн улс төрийн амжилтад хүрэх арга зам) номоо хэвлүүлсэн байдаг.¹

Зөөлөн хүчний бодлого гэдэгт албадлага, түрэмгийлэл, цэрэг зэвсэг, байлдаан тулаан, заналхийлэл үзүүлэх гэсэн санхүү, хөрөнгө мөнгөний ихээхэн зардал шаардсан үйл ажиллагаа бус харин хэл, соёл, урлаг, боловсрол, улс төрийн үзэл суртал, үнэт зүйл, гадаад бодлогын манлайллаар бусдыг татах, нөлөөллөө тогтоох, улмаар зорилгодоо хүрэх гадагш чиглэсэн бодлогыг ойлгодог.²

Английн эрдэмтэн Дэвид Болдвин “албадлага гэхээс илүүтэйгээр зөвшилцөл, ятган итгүүлэх, бусдыг татах чадварыг ашиглан олон

улсын тавцанд шаардлагатай үр дүндээ хүрэхийг зөөлөн хүч” гэж тодорхойлсон³ бөгөөд “зөөлөн хүч”-ний бодлого нь нийгмийн хүрээнд удирдахуйн соёл, урлаг, боловсролын загвар болон бусад эх үүсвэрүүдийг ашиглах замаар өөрийн бодлого, зорилгодоо итгэн үнэмшүүлж, татан хамааруулах технологи⁴ юм.

Сүүлийн үед манай эрдэмтэдийн зөөлөн хүчний бодлогын талаар бичсэн судалгааны өгүүлүүд цөөнгүй гарч байгаа нь нэн талархууштай. Тухайлбал, Н.Соёлгэрэл: “Евроазийн бүс нутаг дахь “Туркийн зөөлөн хүч”-ний бодлого”⁵, Л.Бямбаханд: “Зөөлөн хүчний бодлого хэрэгжүүлсэн Азийн зарим орны туршлага, Монгол Улсын боломж”⁶, Ш.Батболд: “Зөөлөн хүч”-ний бодлого”⁷ зэрэг бүтээлүүдийг дурьдаж болно.

Дээрх судалгааны ажлууд нь ихэнхдээ “бяртай” орнуудаас хөгжиж байгаа орнуудад явуулж ирсэн зөөлөн хүчний бодлого түүнийг хэрэгжүүлж арга хэлбэрийг онцлон авч үзээд Монголын гадагшаа чиглэсэн зөөлөн хүчний бодлого ямар байх талаарх таамаглал, зөвлөмжийн шинжтэй байна.

1 Ж.Найгийн дээрх бүтээлд “зөөлөн хүч”-ийг: 1-рт, Соёл, урлаг, боловсрол 2-рт, Улс төрийн үзэл суртал 3-рт, Гадаад бодлого гэсэн гурван үндсэн бүрэлдэхүүн хэсгээс бүрдэх ба соёл, урлаг, боловсрол нь тухайн нийгэм, үндэстэний уламжлал болох үнэ цэнээс бүрдэж байхад гадаад бодлого нь субъектив шинжтэй хамаарал бүхий зонхилох бодлогын олон талт хамаарал байдаг хэмээн бичжээ.

2 Nye Jr, J. S. (2004). *Soft power: The means to success in world politics*. Public affairs” New York: Public Affairs (2004).

3 Baldwin, D. A. (1979). *Power analysis and world politics: New trends versus old tendencies*. World politics, 31(2), 161-194.

4 Батжаргал Н. Олон улсын харилцааны орчин үеийн онолын товч тойм. УБ (2014): 48-50.

5 Соёлгэрэл Н. “Евроазийн бүс нутаг дахь “Туркийн зөөлөн хүч”-ний бодлого. Олон улс судлал, УБ., (2014) №4.

6 Бямбаханд Л. “Зөөлөн хүчний бодлого хэрэгжүүлсэн Азийн зарим орны туршлага, Монгол Улсын боломж”. Стратегийн судалгаа, УБ., (2015) № 70.

7 Батболд Ш. “Зөөлөн хүчний бодлого ба Монгол Улс”. *Рах Mongolica* сэтгүүл. 2016 №2.

Энэхүү судалгааг зөөлөн хүчний бодлогын нөлөөнд өртөж буй улсын иргэд хэрэгжүүлэгч улсын талаар эерэг хандлагатай болж төлөвшдөг гэсэн онол манай иргэдийн хувьд хэр зэрэг үндэслэлтэй болохыг авч үзсэн. Тухайлбал, Шинэ Зеланд улсад хэрэгжүүлсэн Хятадын зөөлөн хүчний бодлогын үр дүнд Хятадын хөрөнгө оруулалтын талаарх Шинэ Зеландын иргэдийн хандлага эерэгээр өөрчлөгдсөн болохыг эмпирик судалгаагаар нотолсон⁸ байдаг. Түүнчлэн Хятадын хөрөнгө оруулалтын талаар Нигери улсын 10 иргэн тутмын 7 нь эерэг хандлагатай байсан⁹ бөгөөд Тунис,


Ливан, Мексик, Израйл, Өмнөд Африк, Бразил зэрэг улсуудад мөн адил эерэг хамаарал үзүүлсэн. Энэ нь Хятадаас Африк, Ойрхи Дорнод болон Латин Америкийн улсуудад явуулж буй зөөлөн хүчний бодлого амжилттай хэрэгжиж буйн илрэл байх магадлалтай.

Бид энэхүү судалгаандаа “бяртай” улсуудын Монгол улсад явуулж буй зөөлөн хүчний бодлогын нэгэн арга хэрэгсэл нь хөрөнгө оруулалт юм гээд тэдний хөрөнгө оруулалт иргэдэд хэрхэн нөлөөлж, түүнд хандах хандлага хэрхэн өөрчлөгдөж байгааг эмпирик судалгааны үр дүнд түшиглэн задлан шинжилж, учир шалтгааныг нь илрүүлэх оролдлого хийлээ.

Гадаадын хөрөнгө оруулалтын талаарх олон нийтийн хандлага

Монгол Улс дахь гадаадын хөрөнгө оруулалтын талаарх олон нийтийн хандлагыг тодруулах үүднээс 18-аас дээш насны 383 иргэнийг хамруулан

олон нийтийн санаа бодлын судалгааг зохион байгуулсан. Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн мэдээллийг доорх графикаар харуулав.



Baby Boomers	Gen X	Gen Y	Gen Z
59-өөс дээш насныхан	39-58 насныхан	26-38 насныхан	25-аас доош насныхан
5%	34,9%	22,2%	37,9%

8 Li, W. W. (2007). *Understanding Chinese international students' gambling experiences in New Zealand* (Doctoral dissertation, The University of Waikato).

9 Global attitude survey. Spring 2019. International opinions of China. Pew Research Center. Available at <https://www.pewresearch.org/global/2019/12/05/attitudes-toward-china-2019/>

Боловсролын түвшин



Ажил эрхлэлтийн байдал




Ерөнхий үзүүлэлтүүдээр түүврийн шинж чанарыг харж үзэхэд хүн ам зүйн хувьд жигд тархалттай, нас залуу боловч бүх үеийг төлөөлж чадахуйц, салбар бүрт ажилладаг, боловсролын түвшин ялгаатай иргэдийг хамруулсан. Өөрөөр хэлбэл, энэхүү түүвэр судалгаа нь 5% алдааны хязгаарт иргэдийн гадаадын хөрөнгө оруулалтын талаарх хандлагыг бүрэн төлөөлөх чадвартай гэж үзэж болно.

Судалгаанд оролцогчдын нас, боловсрол, орлогын түвшин, мэдээллийн олон эх сурвалж ашиглалт, гадаадад амьдран суусан хугацаа зэрэг хүн ам

зүйн хувьсагчууд болон тухайн улсын хөрөнгө оруулалтад итгэх түвшин, гадаадын хөрөнгө оруулалтын тухай мэдлэг гэх үүсмэл хувьсагчдын хооронд статистик харилцан хамаарал байгаа эсэхийг тодруулах зорилготой ажилласан. Ингэхдээ Монгол улсад хөрөнгө оруулагч долоон улсыг сонгон, тухайн орнуудаас орж ирж буй хөрөнгө оруулалтад итгэдэг эсэхийг 5 түвшин бүхий асуулгаар тодруулсан бөгөөд судалгааны үр дүнг об'ектив байлгах үүднээс 8 асуулт бүхий тестээр гадаадын хөрөнгө оруулалтын тухай ерөнхий мэдлэгийн түвшинг тогтоосон болно.

ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ 2018



Эх сурвалж: www.1212.mn

2018 оны байдлаар бидний сонгон авсан долоон улсаас Монгол улсад оруулсан хөрөнгө оруулалт нь гадаадын шууд хөрөнгө оруулалтын 88%-ийг эзэлж байгааг дээрх графикт үзүүллээ. Мөн эдгээр улсуудын талаар олон нийт маш сайн ойлголттой байдаг тул судалгааны асуулгыг бөглөхөд ямарваа нэг хүндрэл гараагүй юм.

Доорх графикт нэр бүхий долоон улсын Монголд оруулж буй хөрөнгө оруулалтын талаар олон нийт ямар хандлагатай байгааг харуулсан бөгөөд ерөнхий дүнгээр Оросын болон Японы хөрөнгө оруулалтад хамгийн ихээр итгэж байгаа бөгөөд Монголын эдийн засагт чухал хувь нэмэр болно хэмээн үзсэн байна. Харин Хятадын хөрөнгө оруулалтад хамгийн ихээр эргэлзэж, бага итгэл үзүүлсэн байгааг харж болно.

Нарийвчлан шинжлэх үүднээс хувьсагч хоорондын параметрийн бус хамаарлыг Спирманы ранкаар тодруулж Хүснэгт 2-г үзүүллээ. Судалгааны үр дүнг багцлан харахад:

1. Иргэд гадаадын хөрөнгө оруулалтын тухай мэдлэг сайтай байх тусам Өмнөд Солонгос, Австрали, Канад гэх мэт гуравдагч хөршөөс орж ирж буй хөрөнгө оруулалтад илүү итгэж, улс орны хөгжилд сайнаар нөлөөлнө гэж үзэж байна. Мөн хөрөнгө оруулалтын тухай мэдлэг сайтай байх нь Японы хөрөнгө оруулалтад итгэх итгэлийг нэмэгдүүлдэг. Харин уламжлалт Орос, Хятад, Америк гэх мэт улсуудын хөрөнгө оруулалтад итгэл түвшин нь тухайн хүний хөрөнгө оруулалтын тухай мэдлэг мэдээллээс үл хамаарч байна.
2. Иргэдийн боловсролын түвшин өндөр байх тусам Австрали болон Канадын хөрөнгө оруулалтад итгэх хувь өндөр байна. Өөрөөр хэлбэл, зөвхөн боловсрол өндөртэй хүмүүс Монгол улсын уул уурхайн салбарт орж буй гадаадын шууд хөрөнгө оруулалт нь улс орны хөгжилд чухал хувь нэмэр оруулна гэдгийг

ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАД ИТГЭХ ТҮВШИН



ойлгодог. Боловсролын түвшин доогуур байх тусмаа уул уурхайн хөрөнгө оруулалтад итгэхгүй байгаа нь тэдгээрт зориулсан, хялбаршуулсан мэдээлэл хомс төдийгүй уул уурхайг тойрсон элдэв сөрөг мэдээлэл нийгэмд зонхилж байгааг нотолж байна.

3. Мөн гадаадад суралцсан хугацаа урт байх тусам Канад болон Австралийн хөрөнгө оруулалтад итгэдэг нь харагдаж байна. Гэвч гадаадад амьдарсан болон ажиллаж байсан хугацаанаас аль нэг улсын хөрөнгө оруулалтад итгэх түвшин төдийлөн хамаардаггүй гэдгийг судалгааны дүнгээс харж болно.
4. Хятад болон Өмнөд Солонгосын хөрөнгө оруулалтад итгэх ерөнхий хандлага өндөр биш боловч иргэдийн наснаас урвуу хамаарал илэрсэн. Өөрөөр хэлбэл, нас залуу

байх тусам Хятадаас болон Өмнөд Солонгосоос хөрөнгө оруулалт татах нь улс орны хөгжилд ач холбогдолтой хэмээн үзэж байна. Монголын залуу үеийнхэн Хятад болон Өмнөд Солонгосын хөрөнгө оруулалтад ямарваа нэгэн цензургүйгээр итгэх хандлагатай байгаа нь тэдгээр улсуудын зөөлөн хүчний нөлөө өндөр байгааг харуулж байна.

Судалгаанаас гарч буй үр дүнгүүдийг цаашид лавшруулан судлах нэн шаардлагатай бөгөөд бид энэхүү өгүүллийн хүрээнд 4-р дүгнэлт буюу Хятад болон Өмнөд Солонгосын хөрөнгө оруулалтад залуу үеийнхэн голчлон итгэж байгаа шалтгааныг тодруулахын тулд бэсрэг кейс судалгаа хийв.

Монгол Улс дахь Хятад болон Өмнөд Солонгосын зөөлөн хүчний бодлогын нөлөө

Ази тивд Япон, БНСУ, Сингапур, “зөөлөн хүч”-ээр тэргүүлдэг бөгөөд сүүлийн жилүүдэд БНСУ, БНХАУ-ын эдийн засаг хүчирхэгжихийн хэрээр “зөөлөн хүчний бодлого” нь дэлхий дахинд нөлөөгөө тогтоох нэг чухал хэрэгсэл болсон. Зөвхөн Азид төдийгүй Африк, Өмнөд Америк, Европ тивд хүрээгээ тэлсээр байна.

“The soft power 30” буюу зөөлөн хүчний бодлогыг амжилттай хэрэгжүүлж байгаа 30 тэргүүлэгч

улсын талаарх 2019 оны Портландын судалгааг авч үзвэл БНХАУ нь дэлхийд 27-р байранд, харин Ази тивийн 10 улсаас 4-р байранд буюу Япон, Өмнөд Солонгос, Сингапурын дараа орж байна¹⁰.

БНХАУ-ын зөөлөн хүчний илрэл болох Кунфу, Күнзийн сургуулиудаас гадна “Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк” байгуулагдаж, бүс нутагт санхүүгийн манлайллаа тогтоож эхэлсэн байдаг. Харин БНСУ-ын хувьд

10 The soft power 30. A Global Ranking of Soft Power (2019) Portland. USC Center on Public Diplomacy; retrieved from <https://softpower30.com/wp-content/uploads/2019/10/The-Soft-Power-30-Report-2019-1.pdf> , www.mlsp.gov.mn; Maxima Media тайлан 2018 он

энтертэйнмент салбарын хөгжлөөр дэлхийд тэргүүлэгч улсуудын эгнээнд аль хэдийнэ нэгдэн орсон байна.

Энэхүү өгүүллийн зорилгод нийцүүлэх үүднээс залуучуудын санаа бодолд хамгийн ихээр нөлөөлөхүйц салбарууд болох хэлний сургалт, боловсролын солилцоо, аялал жуулчлал, ажиллах хүчний шилжилт, энтертэйнмент буюу үзвэр үйлчилгээний салбарыг Хятад болон Өмнөд Солонгосын жишээн дээр тусгайлсан авч үзсэн болно. Дараах хүснэгтэд Монгол улсын хэмжээнд тухайн хоёр улс голлох таван чиглэлээр ямар байр суурь эзлэж байгааг тодруулав.

Монголын залуу үеийнхэн дунд Хятад болон Өмнөд Солонгос улсууд эерэг имиджтэй байгаа нь дээрх 5 салбарын нөлөөлөл бөгөөд тэр дундаа залуучуудын хамгийн ихээр татагдаж байгаа энтертэйнмент, боловсролын салбарын нөлөө болов уу хэмээн таамаглаж байна. Эдгээр хамаарлыг илүү тодруулах үүднээс нарийвчилсан судалгааг үргэлжлүүлэх хэрэгтэй төдийгүй зөөлөн хүчний бодлогын чиглэлээр гарч буй өгүүлүүдийн дэвшүүлж буй санааг тоон судалгааны үр дүнгүүдээр баталгаажуулах шаардлагатайг тэмдэглэж байна.

Хүснэгт 1	Шалгуурууд	Хятад	Өмнөд Солонгос
Хэл, соёлын сургалт	Албан ёсны институт бий эсэх	Күнзийн институт	Сэжун институт
	Тухайн хэлийг суралцагчдын тоо өсч буй эсэх	Тийм	Тийм
	Тухайн хэлийг эзэмшсэн хүмүүсийн тоон эрэмбэ	3-рт	5-рт
Боловсролын солилцоо	Засгийн газар хоорондын тэтгэлэг бий эсэх	Тийм	Тийм
	Оюутнуудын тоо өсч буй эсэх	Тийм	Тийм
	Оюутнуудын тооны эрэмбэ	1-рт	3-рт
Аялал жуулчлал	Аялал жуулчлалын салбарын хөрөнгө оруулалтад голлох байр суурь эзэлж байгаа эсэх	Тийм	Тийм
	Монголд ирж буй жуулчдын тоон эрэмбэ	1-рт	3-рт
	Монголоос явах жуулчдын тоон эрэмбэ	1-рт	2-рт
Ажиллах хүчний шилжилт	Монголоос явах ажиллах хүчний шилжилт өсч буй эсэх	Тийм	Тийм
	Ажиллах хүчний шилжилтийн тоон эрэмбэ	3-рт	1-рт
Энтертэйнмент	Медиа салбарын нөлөөлөл	Их	Их
	Урлагийн салбарын нөлөөлөл	Их	Их
	Спортын салбарын нөлөөлөл	Их	Их

Эх сурвалж: www.1212.mn ; www.mecss.gov.mn;

Дүгнэлт

Хөрөнгө оруулагч улсуудын талаарх олон нийтийн хандлага нь тэдгээр улсуудын зөөлөн хүчний бодлого, түүний нөлөөллөөс хамаардаг болох нь олон улсын судалгаануудаас харагдаж байна. Энэхүү судалгааны үр дүнд Хятад болон Өмнөд Солонгосоос Монгол улсад орж ирж буй хөрөнгө оруулалтанд итгэх хандлага Монголын залуучуудын дунд зонхилж байгааг илрүүлсэн.

Залуучууд ахмад үеэс илүү эдгээр улсуудын хөрөнгө оруулалтад итгэл үзүүлж байгаа нь зөөлөн хүчний нөлөө

тэдний дунд их байгааг харуулж байна. Хятад, Өмнөд Солонгосын Монгол улсад явуулж буй зөөлөн хүчний бодлого хэл, боловсролын солилцоо, аялал жуулчлал, энтертейнмент салбарт түлхүү илэрч байгаа бөгөөд залуучуудын төсөөлөл эерэг болоход нөлөөлж буй гол хүчин зүйлс юм.

Энэхүү судалгаа нь гадаад улсуудын зөөлөн хүчний нөлөөллийг нийгэм соёлын талаас нь нарийвчлан дэлгэрүүлэх зорилго бүхий судлаачдад нэгэн эх сурвалж болно хэмээн итгэж байна.

Хүснэгт 2		Сpearman's rho							
		Америкийн хөрөнгө оруулагчид итгэх түвшин	Оросын хөрөнгө оруулагчид итгэх түвшин	Хятадын хөрөнгө оруулагчид итгэх түвшин	Өмнөд Солонгосын хөрөнгө оруулагчид итгэх түвшин	Японы хөрөнгө оруулагчид итгэх түвшин	Австралийн хөрөнгө оруулагчид итгэх түвшин	Канадын хөрөнгө оруулагчид итгэх түвшин	
Нас	Correlation Coefficient	-0.058	-0.005	-1.05*	-1.56**	0.015	-1.52**	-1.30*	
	Sig. (2-tailed)	0.255	0.918	0.039	0.002	0.774	0.003	0.011	
	N	383	383	383	383	383	383	383	
Боловсролын түвшин	Correlation Coefficient	.127*	0.073	0.069	0.077	0.068	.204**	.185**	
	Sig. (2-tailed)	0.013	0.156	0.177	0.131	0.182	0.000	0.000	
	N	383	383	383	383	383	383	383	
Орлогын түвшин	Correlation Coefficient	0.047	-0.036	-0.055	-0.046	0.055	0.055	0.043	
	Sig. (2-tailed)	0.361	0.482	0.283	0.366	0.285	0.280	0.403	
	N	383	383	383	383	383	383	383	
Гадаадад амьдарсан хугацаа	Correlation Coefficient	0.036	0.038	.118*	0.076	0.066	0.054	0.070	
	Sig. (2-tailed)	0.484	0.453	0.021	0.139	0.201	0.294	0.174	
	N	383	383	383	383	383	383	383	
Гадаадад сурагдсан хугацаа	Correlation Coefficient	0.074	0.030	.102*	0.062	0.043	.164**	.192**	
	Sig. (2-tailed)	0.149	0.556	0.047	0.230	0.406	0.001	0.000	
	N	382	382	382	382	382	382	382	
Гадаадад ажилласан хугацаа	Correlation Coefficient	0.023	-0.055	-0.098	-0.043	0.044	-0.063	-0.044	
	Sig. (2-tailed)	0.648	0.282	0.056	0.399	0.386	0.217	0.393	
	N	383	383	383	383	383	383	383	

Хүснэгт 2		Хүснэгт 2							
		Мэдээллийн олон суваг ашиглах чадвар	Correlation Coefficient	Америкийн хөрөнгө оруулагчид итгэх түвшин	Оросын хөрөнгө оруулагчид итгэх түвшин	Хятадын хөрөнгө оруулагчид итгэх түвшин	Өмнөд Солонгосын хөрөнгө оруулагчид итгэх түвшин	Лпоны хөрөнгө оруулагчид итгэх түвшин	Австралийн хөрөнгө оруулагчид итгэх түвшин
Spearman's rho	Correlation Coefficient	.144**	.147**	0.082	0.072	.120*	.149**	.123*	
	Sig. (2-tailed)	0.005	0.004	0.107	0.157	0.019	0.003	0.016	
N		383	383	383	383	383	383	383	
	Correlation Coefficient	0.018	0.055	0.095	.133**	.128*	.208**	.220**	
N	Sig. (2-tailed)	0.731	0.281	0.062	0.009	0.012	0.000	0.000	
		383	383	383	383	383	383	383	

** Correlation is significant at the 0.01 level (2-tailed)

* Correlation is significant at the 0.05 level (2-tailed).

Ашигласан материал

- Nye Jr, J. S. (2004). Soft power: The means to success in world politics. Public affairs.
- Baldwin, D. A. (1979). Power analysis and world politics: New trends versus old tendencies. World politics, 31(2), 161-194.
- Global attitude survey. (2019). International opinions of China. Pew Research Center
- Батжаргал Н. (2014). Олон улсын харилцааны орчин үеийн онолын товч тойм. УБ: 48-50.
- Соёлгэрэл Н. “Евроазийн бүс нутаг дахь “Туркийн зөөлөн хүч”-ний бодлого. Олон улс судлал, УБ., (2014) №4.
- Бямбаханд Л. “Зөөлөн хүчний бодлого хэрэгжүүлсэн Азийн зарим орны туршлага, Монгол Улсын боломж”. Стратегийн судалгаа, УБ., (2015) № 70.
- Батболд Ш. “Зөөлөн хүчний бодлого ба Монгол Улс”. Рах Mongolica сэтгүүл. 2016 №2.
- The soft power 30. A Global Ranking of Soft Power (2019) Portland. USC Center on Public Diplomacy; retrieved from <https://softpower30.com/wp-content/uploads/2019/10/The-Soft-Power-30-Report-2019-1.pdf>
- PwC (2019). Understanding Chinese Investment in New Zealand, research report
- Үндэсний статистикийн хороо www.1212.mn;
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам www.mecss.gov.mn;
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам www.mlsp.gov.mn

The influence for soft power and public attitude on foreign investment among Mongolians

Ariunsan Gantuya*

*School of International & Public Affairs,
Shanghai Jiaotong University, Shanghai, China
email: gariunsan@sjtu.edu.cn
<https://orcid.org/0000-0003-4585-5056>*

Tumurchuluun Zaya

*School of International Relations & Social Studies,
University of the Humanities, Ulaanbaatar, Mongolia
email: zaya.t@humanities.mn
<https://orcid.org/0000-0002-4313-6915>*

Abstract: *The main goal of this article is to determine the public attitude on foreign investment among Mongolians based on the soft power theory that the general attitude of a nation could influence the way of perceiving foreign investment. For this purpose, 383 representative samples were surveyed for correlational analysis. Based on the statistical results, a comparative analysis on China and South Korean soft power influence among Mongolian youth were elaborated further. This article is complementary to soft power studies in a narrow sense that counts its empirical importance.*

Keywords: *foreign investment; soft power; public attitude;*

<i>The day of submission:</i>	2020.3.31
<i>Completion of review:</i>	2020.5.18
<i>Final decision for acceptance:</i>	2020.6.02